



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хашаат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/107/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Архангай аймаг

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитор П.Цэцэгдулам

Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	1
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.24 № 23
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

ХАШААТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
А.АРИУНБУЯН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хашаат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Т. Байгалмаа* Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,562,085.79	54,283,385.79
35	БАРАА МАТЕРИАЛ	27,562,085.79	54,283,385.79
35400	Хангамжийн материал	27,562,085.79	54,283,385.79
35410	Бичиг хэргийн материал	4,712,030.00	7,298,390.00
35420	Аж ахуйн материал	18,300,555.79	23,540,295.79
35430	Сэлбэг хэрэгсэл	2,303,000.00	3,880,200.00
35440	Түлш, шатах тослох материал	1,430,000.00	1,095,000.00
35450	Барилгын засварын материал	816,500.00	769,500.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	17,700,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,018,770,624.84	1,025,953,828.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,018,770,624.84	1,025,953,828.95
39200	Биет хөрөнгө	989,906,958.20	999,056,828.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	500,204,255.99	563,653,834.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-45,683,768.16	-72,894,485.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	173,627,550.00	173,627,550.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-76,193,235.91	-92,945,261.19
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	140,089,485.96	195,799,495.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-81,789,014.32	-102,292,995.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,548,387.06	58,548,387.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,397,303.08	-41,153,343.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	777,197,800.11	777,197,800.11
39215	Хуримтлагдсан элэгдэл	-420,111,699.45	-460,898,653.30
39217	Ном	414,500.00	414,500.00
39300	Биет бус хөрөнгө	28,863,666.64	26,897,000.00
39301	Програм хангамж	6,200,000.00	6,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,858,333.36	-5,825,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	26,522,000.00	26,522,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,046,332,710.63	1,080,237,214.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,046,332,710.63	1,080,237,214.74
51	Засгийн газрын хувь оролцоо	1,046,332,710.63	1,080,237,214.74
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	576,458,170.68	576,458,170.68
51200	Хуримтлагдсан үр дүн	256,889,490.77	290,793,994.88
51210	Өмнөх үеийн үр дүн	256,889,490.78	256,889,490.77
51220	Тайлант үеийн үр дүн		33,904,504.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,985,049.18	212,985,049.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,046,332,710.63	1,080,237,214.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	661,155,345.00	552,088,464.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	271,315,017.00	48,197,579.00
120	Нийтлэг татварын бус орлого	271,315,017.00	48,197,579.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	271,315,017.00	2,950,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,048,000.00	2,950,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	270,267,017.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	44,449,579.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	798,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	389,840,328.00	503,890,885.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,926,528.00	17,788,685.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	4,339,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,926,528.00	13,449,185.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	361,913,800.00	486,102,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	361,913,800.00	486,102,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	475,799,014.56	518,183,959.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,799,014.56	492,410,959.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,791,239.56	432,526,558.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,834,227.00	222,542,526.75
210101	Үндсэн цалин	224,834,227.00	222,542,526.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,758,873.00	28,715,521.00
210201	Тэтгэврийн даатгал	19,090,788.93	20,108,777.51
210202	Тэтгэмжийн даатгал	2,244,266.81	2,235,038.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,795,413.45	1,788,038.91
210204	Ажилгүйдлийн даатгал	420,763.07	416,271.98
210205	Эрүүл мэндийн даатгал	4,207,640.74	4,167,394.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,502,665.00	11,173,982.00
210301	Гэрэл, цахилгаан	2,977,665.00	3,184,782.00
210302	Түлш, халаалт	8,525,000.00	7,989,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,705,360.00	33,188,830.00
210401	Бичиг хэрэг	2,900,700.00	2,523,640.00
210402	Тээвэр, шатахуун	14,291,760.00	12,237,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,048,000.00	947,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	24,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,712,000.00	13,074,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,752,900.00	4,381,810.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,641,900.00	2,150,100.00
210604	Урсгал засвар	2,641,900.00	2,150,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,657,000.00	1,714,000.00
210702	Дотоод албан томилолт	1,657,000.00	1,714,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,634,238.00	1,407,794.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,838,078.00	1,032,770.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	208,160.00	187,024.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	188,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,056,976.56	131,633,804.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,873,920.00	19,657,420.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,200,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,983,056.56	111,976,384.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,007,775.00	59,884,401.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,925,700.00	3,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,925,700.00	3,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,082,075.00	56,184,401.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,082,075.00	56,184,401.25
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	25,773,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	25,773,000.00
221001	Их засвар	0.00	25,773,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	185,356,330.44	33,904,504.11
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	185,356,330.44	33,904,504.11

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	256,889,490.77	1,046,332,710.63
2	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	256,889,490.77	1,046,332,710.63
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	256,889,490.77	1,046,332,710.63
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	33,904,504.11	33,904,504.11
5	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	576,458,170.68	212,985,049.18	290,793,994.88	1,080,237,214.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	390,888,328.00	506,840,885.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,048,000.00	2,950,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,048,000.00	2,950,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,048,000.00	2,950,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,048,000.00	2,950,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	389,840,328.00	503,890,885.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,926,528.00	17,788,685.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	4,339,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,926,528.00	13,449,185.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	361,913,800.00	486,102,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	361,913,800.00	486,102,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	361,516,328.00	406,357,875.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	361,516,328.00	406,357,875.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	336,508,553.00	346,473,473.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,834,227.00	222,542,526.75
210101	Үндсэн цалин	224,834,227.00	222,542,526.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,758,873.00	28,715,521.00
210201	Тэтгэврийн даатгал	19,090,790.00	20,108,778.10
210202	Тэтгэмжийн даатгал	2,244,267.00	2,235,038.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,795,413.00	1,788,038.69
210204	Ажилгүйдлийн даатгал	420,763.00	416,271.63
210205	Эрүүл мэндийн даатгал	4,207,640.00	4,167,394.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,247,665.00	10,105,782.00
210301	Гэрэл, цахилгаан	2,977,665.00	3,184,782.00
210302	Түлш, халаалт	7,270,000.00	6,921,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,320,630.00	34,434,100.00
210401	Бичиг хэрэг	5,231,570.00	5,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,291,760.00	11,639,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,048,000.00	947,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	24,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,712,000.00	13,624,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,037,300.00	2,998,850.00
2105	Нормативт зардал	0.00	2,037,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	2,037,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	252,500.00	1,967,600.00
210604	Урсгал засвар	252,500.00	1,967,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,657,000.00	1,714,000.00
210702	Дотоод албан томилолт	1,657,000.00	1,714,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,634,238.00	1,407,794.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,838,078.00	1,032,770.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	208,160.00	187,024.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	188,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,803,420.00	43,548,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,803,420.00	43,548,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,007,775.00	59,884,401.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,925,700.00	3,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,925,700.00	3,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,082,075.00	56,184,401.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,082,075.00	56,184,401.25
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,372,000.00	100,483,010.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	29,372,000.00	100,483,010.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,372,000.00	100,483,010.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,372,000.00	100,483,010.00
220001	Барилга байгууламж	0.00	20,000,000.00
221001	Их засвар	0.00	4,148,000.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	1,625,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,372,000.00	74,710,010.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-29,372,000.00	-100,483,010.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	486,602,200.00	437,750,507.75	48,851,692.25	89.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,827,600.00	338,267,497.75	35,560,102.25	90.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,127,600.00	334,567,497.75	35,560,102.25	90.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,150,100.00	222,542,526.75	7,607,573.25	96.69
210101	Үндсэн цалин	230,150,100.00	222,542,526.75	7,607,573.25	96.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,070,300.00	28,715,521.00	2,354,779.00	92.42
210201	Тэтгэврийн даатгал	21,864,300.00	20,108,778.10	1,755,521.90	91.97
210202	Тэтгэмжийн даатгал	2,301,500.00	2,235,038.08	66,461.92	97.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,841,200.00	1,788,038.69	53,161.31	97.11
210204	Ажилгүйдлийн даатгал	460,300.00	416,271.63	44,028.37	90.43
210205	Эрүүл мэндийн даатгал	4,603,000.00	4,167,394.50	435,605.50	90.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,500,000.00	10,105,782.00	3,394,218.00	74.86
210301	Гэрэл, цахилгаан	4,850,000.00	3,184,782.00	1,665,218.00	65.67
210302	Түлш, халаалт	8,500,000.00	6,921,000.00	1,579,000.00	81.42
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	0.00	150,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,350,000.00	21,943,700.00	1,406,300.00	93.98
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00	11,380,950.00	619,050.00	94.84
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	947,000.00	153,000.00	86.09
210404	Ном, хэвлэл	50,000.00	24,000.00	26,000.00	48.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,200,000.00	1,592,900.00	607,100.00	72.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,998,850.00	1,150.00	99.96
2105	Нормативт зардал	2,100,000.00	2,037,200.00	62,800.00	97.01
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,100,000.00	2,037,200.00	62,800.00	97.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,007,200.00	1,967,600.00	39,600.00	98.03
210604	Урсгал засвар	2,007,200.00	1,967,600.00	39,600.00	98.03
2107	Томилот, зочны зардал	3,000,000.00	1,714,000.00	1,286,000.00	57.13
210702	Дотоод албан томилот	3,000,000.00	1,714,000.00	1,286,000.00	57.13
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,400,000.00	992,218.00	1,407,782.00	41.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	617,194.00	1,382,806.00	30.86
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	187,024.00	12,976.00	93.51
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	188,000.00	12,000.00	94.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,550,000.00	44,548,950.00	18,001,050.00	71.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,000,000.00	44,548,950.00	17,451,050.00	71.85

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	0.00	550,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,700,000.00	3,700,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,700,000.00	3,700,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,700,000.00	3,700,000.00	0.00	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	112,774,600.00	99,483,010.00	13,291,590.00	88.21
220001	Барилга байгууламж	39,000,000.00	39,000,000.00	0.00	100.00
221001	Их засвар	10,774,600.00	9,314,114.00	1,460,486.00	86.45
222001	Тоног төхөөрөмж	63,000,000.00	51,168,896.00	11,831,104.00	81.22
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	486,602,200.00	437,750,507.75	48,851,692.25	89.96
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	348,327,600.00	434,800,507.75	-86,472,907.75	124.83
320001	Орон нутгийн төсвөөс	348,327,600.00	434,800,507.75	-86,472,907.75	124.83
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	138,274,600.00	2,950,000.00	135,324,600.00	2.13
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	2,950,000.00	-2,450,000.00	590.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	137,774,600.00	0.00	137,774,600.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	22	3	88.00
620001	Удирдах ажилтан	7	7	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13	10	3	77.00
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	7	2	78.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14	13	1	93.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.00

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,905,976.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,905,976.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,905,976.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,490,400.00
210401	Бичиг хэрэг	200,000.00
210402	Тээвэр, шатахуун	258,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,032,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	415,576.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	415,576.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,905,976.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,905,976.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,905,976.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хашаат сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Цэцэгдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хашаат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хашаат сумын ЗДТГ нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах чиг үүрэг бүхий аймаг, сумын ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Нутгийн өөрийн удирдлагыг бэхжүүлэх сумын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, сумын нийгмийн салбарын хөгжлийг ахиулах, төр засгийн бодлого шийдвэр, хууль тогтоомийг иргэд, хөдөлмөрчдөд байнга хүргэн мэдээлж, сурталчилгааг тогтмол хийх, сумын эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд төрийн шуурхай тасралтгүй үйлчилгээг хангах, бүх шатанд хариуцлага, сахилгыг өндөржүүлсний үндсэн дээр нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, хуулийн дагуу зохицуулан түүний хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”

- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хашаат сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэль сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 486.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 3.2 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	хувь
Бараа материал	27.6	54.3	26.7	96.7
Үндсэн хөрөнгө	1,018.7	1,025.9	7.2	0.7
Нийт хөрөнгө	1,046.3	1,080.2	33.9	3.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,046.3	1,080.2	33.9	3.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,046.3	1,080.2	33.9	3.2

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал эхний үлдэгдлээс 96.7 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 27.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 68.7 сая төгрөг, хандиваар 0.8 сая төгрөг нийт 69.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 42.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 54.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 0.7 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1018.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 74.7 сая төгрөг, хандиваар 44.4 сая төгрөг нийт 119.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 111.9 сая төгрөгийн элэгдлээр буурч 1025.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 33.9 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	270.2	45.2	(225.0)	
Нэмэлт санхүүжилт	27.90	17.8	(10.1)	
Орон нутгийн төсвөөс	361.9	486.1	124.2	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1.0	2.9	1.9	
Үйл ажиллагааны орлого	661.0	552.0	(109.0)	
Цалин, шимтгэлийн зардал	252.5	251.2	(1.3)	
Бараа ажил үйлчилгээний зардал	54.6	48.4	(6.2)	
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5.6	1.4	(4.2)	
Бараа үйлчилгээний бусад зардал	138.0	131.6	(6.4)	
Урсгал шилжүүлэг	25.0	59.8	34.8	
Хөрөнгийн зардал			-	
Үйл ажиллагааны зардал	475.7	492.4	16.7	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	185.3	33.9	-	

Хашаат сумын ЗДТГ-ын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 109.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд нэмэлт санхүүжилт буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 449.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 56.8 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 392.8 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор 486.6 сая төгрөг буюу 93.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь хөрөнгийн зардалтай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгаас 486.1 сая төгрөг, өөрийн орлого 0.5 сая төгрөг нийт 486.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 486.1 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 2.9 сая төгрөг төвлөрүүлэн нийт 489.0 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 437.7 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 51.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний бусад зардал 48.9 сая төгрөг хэмнэгдэж, төсөвт байгууллагын өөрийн орлого 2.4 сая төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 1.0 сая төгрөг, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас үлийн цагаан огтоно устгалын зардал 12.0 сая төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын зардал аймгийн ИТХ-аас 0.3 сая төгрөг, хандиваар 4.3 сая төгрөг, үндсэн санхүүжилтээс 0.2 сая төгрөг нийт 17.8 сая төгрөг ирсэн байна. Гүйцэтгэлээр тээвэр шатахууны зардалд 0.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 0.4 сая төгрөг, бичиг хэрэгт 0.2 сая төгрөг, хог хаягдал хортон мэрэгчдийн устгал ариутгалд 12.0 сая төгрөгийг тус тус зарцуулж 4.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хашаат сумын ЗДТГ нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 55.7 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 19.0 сая төгрөгийн өртөг бүхий Номгон багийн конторын барилгыг үндсэн хөрөнгөнд бүртгэж, тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 12 үндсэн зорилтын хүрээнд 78 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 496.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 95.4 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь төсөвт байгууллагын өөрийн орлогоор 0.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 2.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Батлагдсан төсөвт зардлаас 51.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна.
- Төсвийн хөрөнгөөр 4.2 сая төгрөгийн өртөг бүхий конторын тавилга худалдан авсан нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалттай нийцэхгүй байна.
- Тус байгууллага нь 35.0 сая төгрөгийн өртөг бүхий 1 тээврийн хэрэгсэлтэй бөгөөд үндсэн орон тооны жолоочтой цалингийн зардалд 6.1 сая төгрөг, шатахуунд 11.3 сая төгрөг тус тус зарцуулсан байна.
- Тайлант онд 43.3 сая төгрөгийн бэлэн мөнгө, 0.7 сая төгрөгийн бараа материал хандиваар авч бүртгэсэн байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/, Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хашаат сумын ЗДТГ нь тайлант хугацаанд оруулбал зохих 139 мэдээлийг хугацаанд нь мэдээлж, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 23 тушаал, шийдвэрийг бүрэн байршуулсан бол цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6 гүйлгээний 54.9 сая төгрөгийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмжийг хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын *“Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”* 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д *“үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах”* гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 53.1 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

Төсвийн хөрөнгөөр 4.2 сая төгрөгөөр конторын тавилга худалдан авсан нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны *“Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”* 43 дугаар тогтоолын 1.4 *“Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, ... хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны *“Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”* 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилт, хандив тусламжийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн 186.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 183.0 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Залруулагдаагүй 2 алдаа, зөрчлийн материаллаг бус 183.0 сая төгрөг, материаллаг 3.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 4.9 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Албан шаардлага

Засаг даргын нөөц хөрөнгөөс тоног төхөөрөмжид 1.0 сая төгрөг, ЗДТГ-н УАЗ хантер автомашины засварт 2.6 сая төгрөг нийт 3.6 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.1, 3.1.2 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс үзэхэд 201 нэр төрлийн 183.0 сая төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан байна.

Өгсөн зөвлөмж: Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасны дагуу арга хэмжээ авч ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		2	186.9	0	0			1	3.7	1	183.0
	дүн	2	186.9	0	0			1	3.7	1	183.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
		2	59.1	0	0	0	0	2	59.1		0
	дүн	2	59.1	0	0	0	0	2	59.1		0
	Нийт дүн	4	246.1	0	0	0	0	3	62.8	1	183.0